



ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧ НАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2016.07.05 № 3-1/4510
танай _____-ны № _____-т

Монгол Улсын 2017-2019 оны
төсвийн төсөл бэлтгэх тухай

Монгол Улсын Засгийн газар 2016 оны 06 дугаар сарын 28-ний өдрийн хуралдаанаараа "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны төсвийн хязгаар"-ыг баталлаа.

Төсвийн тухай хуулийн 8.3.4-д заасны дагуу батлагдсан төсвийн хязгаарыг төсвийн удирдамжийн хамт хавсралтаар хүргүүлж байна. Төсвийн хязгаар, жилийн төсвийн төсөл боловсруулах удирдамж болон удирдамжийн хавсралт маягтуудыг цахим хэлбэрээр төсвийн ил тод байдлын www.iltod.gov.mn/ болон Сангийн яамны www.mof.gov.mn цахим хуудаснаас татаж авах боломжтой.

Төсвийн тухай хуулийн 8.4.3-т заасны дагуу 2017 оны төсвийн төсөл, 2018-2019 оны төсвийн төсөөллийг төсвийн хязгаарт багтаан, төсвийн төсөл бэлтгэх удирдамж, холбогдох маягтын дагуу боловсруулж 2016 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт №1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017-2019 оны төсвийн төслийг бэлтгэх удирдамж

Хавсралт №2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны төсвийн хязгаар
Хавсралт №3. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналын маягт

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



ХИГАНЦОГТ

005985